



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Г
Барилгын үйл ажиллагаанд оролцогч
байгууллагуудын дотоод хяналтын
жишиг дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- “Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын барилгын техникийн дотоод хяналтын жишиг дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
- Энэ дүрмийг барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, сурталчлах, үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Билэгжаргал/-т даалгасугай.



Х.БАДЕЛХАН

08 00045

Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
11 дүгээр тушаалтын хавсралт

**БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН
БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ЖИШИГ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх, барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, инженер-геологийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд /цаашид “аж ахуйн нэгж, байгуулага” гэх/ барилгын техникийн дотоод хяналтаараа Монгол Улсын хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр тогтоосон хэм хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2. Энэ дурмийг удирдлага болгон аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулж, барилгын техникийн дотоод хяналтын дүрмээ боловсруулж эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр батлуулан хууль тогтоомжийн дагуу мөрдөж ажиллана.

1.3. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, мөн хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэхдээ энэ дурмийг мөрдлөгө болгоно.

1.4. Барилгын техникийн дотоод хяналтын үйл ажиллагааг Барилгын тухай хууль, барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон энэ дүрмээр зохицуулна.

1.5. Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын барилгын техникийн дотоод хяналт нь тогтвортой, тасралтгүй байна.

Хоёр. Барилгын техникийн дотоод хяналтын ажиллах зарчим, зорилго

2.1. Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд Барилгын тухай хуулийн 12, 13, 14, 15, 16, 17 дугаар зүйлд заасан шаардлагын хэрэгжилтийг ханггуулж ажиллана.

2.2. Барилгын техникийн дотоод хяналт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана. Барилгын техникийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтаны үйл ажиллагаа нээлттэй байна.

2.3. Монгол Улсын хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн хэм хэмжээг хэрэгжүүлж ажиллах хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд барилгын техникийн дотоод хяналтын үйл ажиллагааны зорилго оршино.

2.4. Барилгын техникийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр томилсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

2.5. Барилгын техникийн дотоод хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан шалгуулагч этгээдэд адил тэгш хандаж, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн харилцана.

2.6. Тухайн объектын эрсдэл, барилга байгууламжийн төвөгшил, ангилалаас хамааруулан барилгын техникийн дотоод хяналтыг хийх дэс дараалал, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж гүйцэтгэнэ.

2.7. Барилгын техникийн дотоод хяналтыг хэрэгжүүлэгч этгээд холбогдох асуудлын талаар урьдчилан дүгнэлт гаргаж, түүнийгээ батлах замаар хяналт шалгалт хийхийг хориглоно.

2.8. Барилгын техникийн дотоод хяналт нь аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн ажилтны ажиллах чадамж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Барилгын техникийн дотоод хяналтын хамрах хүрээ, чиглэл

3.1. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд барилгын техникийн дотоод хяналтаа эрхэлж буй үйл ажиллагааныхаа чиглэлээр доорхи хууль тогтоомж, норм нормативын баримт бичгээр тогтоосон хэм хэмжээний хэрэгжилтэд чиглүүлж, хяналт тавьж ажиллана. Үүнд:

3.1.1. барилгын тухай хууль, түүнийг дагалдан батлагдсан дүрэм, журам

3.1.2. барилгын норм, дүрэм;

3.1.3. барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;

3.1.4. стандарт.

3.2. Аж ахуйн нэгж, байгууллагын техникийн дотоод хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. барилга байгууламжийн инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх байгууллагын дотоод хяналт;

3.2.2. барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах байгууллагын техникийн дотоод хяналт;

3.2.3. барилгын ажил гүйцэтгэх байгууллагын техникийн дотоод хяналт;

3.2.4.Барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч байгууллагын барилгын техникийн дотоод хяналт;

3.2.5.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл угсралт, засвар үйлчилгээ эрхлэх байгууллагын техникийн дотоод хяналт.

3.3.Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эрхэлж буй үйл ажиллагаанд шаардах барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр хангагдсан байна.

3.4.Байгууллага эрхэлж буй үйл ажиллагааныхаа төлөвлөгөөтэй уялдуулж техникийн дотоод хяналтын төлөвлөгөөгөө боловсруулж, баталж мөрдөнө.

Дөрөв. Барилгын техникийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх бүрэлдэхүүн, чиг үүрэг

4.1.Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч барилгын техникийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "барилгын техникийн дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ.

4.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын техникийн дотоод хяналтын чиг үүргийг гэрээний үндсэн дээр Барилгын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан зөвлөх үйлчилгээний чиглэлийн дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй иргэн, хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

4.3.Барилгын техникийн дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.

4.4.Барилгын техникийн дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

4.5.Барилгын техникийн дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьялагдах нэгж, объектын тоог харгалzan тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

4.6.Барилгын техникийн дотоод хяналт шалгалтын нэгж болон ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.6.1.зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу барилгын техникийн дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дунг тайлагнах;

4.6.2.хяналт шалгалт гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

4.6.3. илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, түүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

4.6.4.шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

4.6.5.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

4.6.6.хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

4.6.7.холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

4.6.8.барилгын техникийн дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;

4.6.9.байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангаж ажиллах;

4.6.10.хэрэгжүүлсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

4.6.11.барилгын техникийн дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

4.6.12.барилгын ажилд зураг төсөл зохиогчоос хяналт тавьж өгсөн, үүрэг даалгаварын биелэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.6.13.барилгын талбайд ажиллаж байгаа механизм, өргөн тээвэрлэх машин, техник хэрэгслийн ажиллагаанд хяналт шалгалт хийх.

4.7.Энэ дүрмийн 4.6-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан барилгын техникийн дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Тав. Барилгын техникийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.Дотоод хяналтын нэгж нь аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааны онцлог, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтыг ажлын тусгайлан төлөвлөгөөг боловсруулан аж ахуйн нэгж, байгууллагын захирлаар батлуулан мөрдөж ажиллана.

5.2.Дотоод хяналтын нэгж нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа шуурхай хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээнэ.

5.3.Аж ахуйн нэгж, байгууллага техникийн дотоод хяналтыг дараах чиглэлүүдээр тус тус хэрэгжүүлнэ. Үүнд:

5.3.1. барилга байгууламжийн инженер-геологийн ажил гүйцэтгэх байгууллагын техникийн дотоод хяналтын үйл ажиллагааг энэ дүрмийн нэгдүгээр хавсралтаар;

5.3.2. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах байгууллагын техникийн дотоод хяналтын үйл ажиллагааг энэ дурмийн хоёрдугаар хавсралтаар;

5.3.3. барилгын ажил гүйцэтгэх байгууллагын техникийн дотоод хяналтын уйл ажиллагааг энэ дурмийн гуравдугаар хавсралтаар;

5.3.4. барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч байгууллагын барилгын техникийн дотоод хяналтын үйл ажиллагааг энэ дүрмийн дөрөвдүгээр хавсралтаар;

5.3.5.өргөх байгууламж, түүний эд агийн үйлдвэрлэл угсралт, засвар үйлчилгээ эрхлэх байгууллагын техникийн дотоод хяналтын үйл ажиллагааг энэ дурмийн тавдугаар хавсралтаар.

Зургаа. Барилгын техникийн дотоод хяналт гүйцэтгэгчийн хүлээх хариуцлага

6.1. Барилгын техникийн дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

6.2. Барилгын техникийн дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэролдуулна.

“Барилгын үйлажиллагаанд оролцогч
байгууллагуудын барилгын техникийн
дотоод хяналтын жишиг дүрэм”-ийн нэгдүгээр
хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН
СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ**

Барилга байгууламжийн инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх байгууллага техникийн дотоод хяналтаар дараах ажлыг гүйцэтгэнэ.

1. Инженер-геологийн судалгааны ажилд:

1.1 Инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгүүлэхээр ирүүлсэн техникийн ба ажлын даалгаварын бүрдэл, баталгаажилт нь Инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх норм дүрэмд заасан шаардлага хангаж байгаа эсэх;

2. Инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх дараах төлөвлөлтийг хянаж баталгаажуулах;

2.1. Тухайн судалгаа хийхээр төлөвлөж байгаа нутаг дэвсгэр, талбай зурvasын инженер-геологийн нөхцлийг тогтоосон үндэслэлд;

2.2 Судалгааны ажлын аргачлал, нэр төрөл нь инженер-геологийн нөхцөлтэй бодитой уялдсан эсэх;

2.3 Судалгааны ажлын нэр төрөл, тоо хэмжээ нь захиалагчийн техникийн ба ажлын даалгавар болон холбогдох норм дүрмийн заалтад нийцэж байгаа эсэх;

3. Төсөл, хөтөлбөрт тусгагдсан хээрийн судалгааны ажлын норм дүрэм, арга, аргачлал, стандартын шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэж байгаа эсэх;

4. Ажлын боловсруулалт нь ажлын норм дүрэм, стандарт, программын заалтын дагуу хэрэгжиж байгаа эсэх;

5. Судалгааны ажлын техникийн тайлан дүгнэлт, зураг зүсэлтийн боловсруулалт норм дүрэм, стандарт, программын заалтын дагуу хэрэгжиж байгаа эсэх;

6. Талбайн болон лабораторийн геотехникийн туршилт шинжилгээний багаж хэрэгслийн техникийн ба стандартын хэмжил зүйн баталгаажуулалт;

7. Хээрийн болон лабораторийн геотехникийн туршилт шинжилгээний үр дүнгийн боловсруулалтын стандарт ба программын мөрдөлт;

8. Өрөмдлөгийн ажлын машин техник, хээрийн болон лабораторийн туршилт шинжилгээний багаж хэрэгслэлийн хэрэглэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартын шаардлагын дагуу ашиглаж байгаа байдал.

❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖

“Барилгын үйл ажиллагаанд оролцогч
байгууллагуудын барилгын техникийн дотоод
хяналтын жишиг дүрэм”-ийн хоёрдугаар
хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ТЕХНИКИЙН ДОТООД ХЯНАЛТ

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах байгууллага техникийн дотоод хяналтаар дараах ажлыг гүйцэтгэнэ.

1. Барилга байгууламжийн инженер хайгуулын судалгааны ажилд:

1.1. Ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн хангамжийн боломж, эрүүл ахуй, галын аюулгүйн нөхцөл, шаардлагад нийцүүлэн тухайн барилга байгууламжийн байршлыг тогтоосон эсэх;

1.2. Архитектур төлөвлөлтийн даалгаварт доорх зүйлийг тусгасан байдалд:

1.2.1.барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал нь хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй нийцэж холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэх;

1.2.2.барилгын хэмжээ, барилгын өндөр, давхрын тоог барилгын норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;

1.2.3.тухайн барилга байгууламжид хамаарах зам, талбай, ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн тогтоосон эсэх;

1.2.4.хүрээлэн байгаа орчин, тохижилт, зам, талбай, ногоон байгууламжийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх зэрэг ажлын хэмжээ, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн тогтоосон эсэх;

1.2.5.инженерийн хангамжийн сүлжээнд холбогдох боломж, техникийн нөхцөлийг оновчтой тусгасан эсэх;

1.2.6.нарны ээвэрлэлт хангах, фасадны зонхилох өнгө, дээвэр, тагтны хашлага, хаалт, материалыг холбогдох норм нормативын баримт бичигт нийцүүлэн төлөвлөсөн эсэх,

1.2.7.инженер хангамжийн шийдэл, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, шаардлагад нийцүүлэх арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгасан эсэх.

1.3.Архитектур төлөвлөлтийн даалгаварыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектор баталсан эсэх;

1.4.Захиалагч архитектур төлөвлөлтийн даалгаварыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж баталсан эсэх;

1.4.Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн болон зураг төслийн даалгаварыг үндэслэж загвар зургийг аймаг, нийслэлийн ерөнхий архитектороор батлуулсан эсэх;

1.5.Техник-эдийн засгийн үндэслэлд барилга байгууламжийн хүчин чадал, төлөвлөлт, техник, технологи, дэд бүтцийн хангамж, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн нөөц, түүхий эд, материалын хангарт, эдийн засгийн үр ашиг, зах зээлд өрсөлдөх чадварыг тодорхойлж харьцуулсан тооцоо, судалгааг гаргаж, тусгасан эсэх;

1.7. Инженер хангамжийн техникийн нөхцөлийг шаардлагатай ачааллын дагуу эрх бүхий хуулийн этгээдээс гаргуулж тодорхойлуулсан эсэх;

1.8. Газрын дэвсгэр зургийг газар олголтын захирамж, байршлын бүдүүвч зураг, инженерийн хангамжийн техникийн нөхцөл зэрэг баримт бичгийг үндэслэн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр холбогдох норм, дүрмийн шаардлагыг хангуйж боловсруулсан эсэх.

2. Зураг төсөл боловсруулах үе шат, үйл ажиллагаанд:

2.1.Батлагдсан загвар зургийг үндэслэн эх загвар зураг (эскиз)-ийг дараах байдлаар боловсруулсан байдалд.

2.1.1.инженер хайгуулын судалгаанд үндэслэн барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх;

2.1.2.тохижилтын зураг төслийг холбогдох норм, дүрмийн шаардлагын дагуу боловсруулсан эсэх;

2.1.3.гудамжны дэлгээсүүдийн зургийг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулсан эсэх;

2.1.4.орчны барилгуудтай уялдуулсан эсэх;

2.1.5.эзлэхүүн төлөвлөлтийг холбогдох норм, дүрэм болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;

2.1.6.барилгын бүтээц, инженерийн хангамжийн ерөнхий шийдлийг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн оновчтой төлөвлөсөн эсэх;

2.1.7.эрүүл ахуй, галын аюулгүй байдлын норм, дүрмийн шаардлагад нийцсэн эсэх;

2.1.8.барилгын давхрын байгуулалт, дотоод зохион байгуулалт, отплол, нүүр тал, өнгөний шийдэл оновчтой эсэх;

2.1.9.нарны тусгалыг тооцсон эсэх;

2.1.10.эрүүл ахуйн болон галын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авсан эсэх.

2.2. Ажлын зураг төслийг дараах байдлаар боловсруулсан байдалд

2.2.1.ажлын зургийг зураг төслийг даалгавар болон эх загвар зургийн дагуу боловсруулсан эсэх;

2.2.2. барилга архитектурын зураг төслийг холбогдох норм, дүрэм болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;

2.2.3. барилга бүтээц, инженер хангамжийн зураг төслийг магадлалаар баталгаажсан инженер хайгуулын судалгааг үндэслэн боловсруулсан эсэх;

2.2.4.барилга бүтээцийн тооцоог холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн тооцсон эсэх:

2.2.5.инженерийн хангамжийн шийдлийг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн тооцож тогтоосон эсэх.

2.2.6. барилга бүтээц, инженер хангамжийн зураг төслийг тооцооны дагуу боловсруулсан эсэх:

2.2.7.ажлын зургийн хэсгүүдийн уялдаа холбоог хооронд нь зөвшилцсэн эсэх:

2.2.8.эрүүл ахуй, гал, инженерийн хангамж болон авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудтай холбогдох ажлын зургийг зөвшилцэн эсэх

2.3.Хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөө M1:500, M1:1000, M1:2000 архитектур төлөвлөлт, технологи, барилга бүтээц, инженерийн хангамжийн байгуулалт, огтлол M1:100, M1:150, M1:200, орчны тойм M1:2000, M1:5000, M1:10000 масштабтайгаар зураг төслийг боловсруулсан эсэх:

2.4.Барилга байгууламжийн төсвийг батлагдсан ажлын зургийн үндэслэж холбогдох норм дурмийн дагуу боловсруулсан эсэх:

2.5.Барилга байгууламжийн зураг төсөлд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн дарга /захирал/ нүүр хуудсанд гарын үсэг зурж, тэмдэг дарж, зохиогч, шалгасан хоёрдогч архитектор, инженер хуудас бүрт гарын үсэг зурж баталгаажуулсан эсэх; /Шалгасан архитектор, инженер нь мэргэшлийн зэрэгтэй байна./

2.6.Зураг төслийг шалгасан инженер, архитектор нь боловсруулсан зохиогчтой давхцаагүй эсэх.

“Барилгын үйл ажиллагаанд оролцогч
байгууллагуудын барилгын техникийн дотоод
хяналтын жишиг дүрэм”-ын гуравдугаар
хавсралт

БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТЕХНИКИЙН ДОТООД ХЯНАЛТ

Барилгын ажил гүйцэтгэгч байгууллага техникийн дотоод хяналтаар
дараах ажлыг гүйцэтгэнэ.

1. Барилга байгууламжийн техникийн баримт бичиг, зохион байгуулалтын ажилд:

- 1.1. Газар олгосон зөвшөөрөл;
- 1.2. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, техникийн нөхцөлийн бүрдүүлэлт;
- 1.3. Улаан шугам тавьсан акт;
- 1.4. Барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл;
- 1.5. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл;
- 1.6. Захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл;
- 1.7. Инженер техникийн ажилчдын мэдээлэл;
- 1.8. Илд далд ажлуудыг актаар баталгаажуулсан байдал,
- 1.9. Өдөр тутмын гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл;
- 1.10. Барилга байгууламжийн ажлын чанар зохион байгуулалтад;
- 1.11. Хэмжин шалгах багаж хэрэгсэл хэрэглэж байгаа эсэх;
- 1.12. Тухайн барилгын зураг төслийн хэрэгжилтэд.

2. Газар шорооны ажилд:

- 2.1. Өндөржилтийг зураг төслийн дагуу хийсэн эсэх /барилгын талбайн/;
- 2.2. Суурийн гүнийг төсөлд заасан хэмжээнд ухсан эсэх, хөрсний бүтэц нь геологийн дүгнэлттэй тохирч буй эсэх;
- 2.3. Шуудууны эргийн налуу тохирч байгаа эсэх;
- 2.4. Асгаас хөрсний нягтуулах үе түүний нягтралт нь шаардлага хангасан эсэх;
- 2.5. Суурийн нүхний хэвтээ тэнхлэгүүд зурагтай тохирч байгаа эсэх;

2.6.Шуудуу, суваг, далангийн чиглэл, төвшин тэмдэгтэйгээ тохирч байгаа эсэх;

2.7.Мөнх цэвдэг, суулттай болон овойдог хөрсийг гэсэх, хөлдөх, чийг авахаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авах.

3.Суурийн ажилд:

3.1. Суурийн хэвтээ тэнхлэгийн шилжилт хүлцлийн хэмжээнд байгаа эсэх;

3.2.суурийн босоо тэнхлэгийн алдац хүлцлийн хэмжээнд байгаа эсэх;

3.3.Суурийн бүтээцийн арматурчлал, хэвтээ босоо заадсын зуурмагийн дүүргэлт, бетоны нягтуулалт, найрлага, бат бэх нь шаардлага хангаж байгаа эсэх;

3.4.Суурийн улны болон дээд төвшин нь заагдсан хэмжээнд байгаа эсэх;

3.5. Суурийн геометрийн хэмжээ нь зураг төсөлд нийцэж буй байдал;

3.6.Суурийн ул нягтуулалт, бүс бетон болон суулт, овойлт, гэсэлтээс хамгаалах арга хэмжээнүүдийг хэрхэн гүйцэтгэсэн байдал;

3.7.Иненер геологийн дүгнэлттэй хөрсний бүтцийн нийцэж байгаа байдал.

4. Өрөгт бүтээцийн байдал:

4.1.Ханын зузаан, дэр хана, нүх, баганы отглол нь тохирч байгаа эсэх;

4.2.Өргийн булан уулзварын торлолт, босоо арматурчлал нь шаардалга хангаж буй эсэх;

4.3.Өргийн хэвтээ, босоо заадсын зуурмагийн дүүргэлт, өрлөгийн систем зөв хийгдсэн эсэх;

4.4.Өргийн зуурмагт налархайжуулагч хольц хэрэглэж байгаа эсэх болон өргийн барьцалдах чадвар нь шаардлага хангаж буй эсэх;

4.5.Өргийн хазайлт, гадаргын тэгш байдал нь шаардлага хангаж буй эсэх;

4.6.Ханын хоорондох алгаслал, ханын өндөр, холбоосгүй үргэлжлэх урт нь зураг төсөлтэй тохирч буй эсэх;

4.7.Бүс бетон, зүрхэвчийг гүйцэтгэсэн болон багана, рамтай хэрхэн холбогдсон байдал;

4.8.Өрлөгийн үндсэн материал чанар стандартын шаардлагад тохирч байгаа эсэх.

5.Хучилтын ажилд:

- 5.1.Хучилтын хавтангийн дэрлэх суулт хэмжээндээ байгаа болон нэг түвшинд тэгш угсрагдсан эсэх;
- 5.2.хавтангийн төгсгөлийн бэхэлгээ, хавтан хоорондох арматурчлал ба зуурмагийн дүүргэлт нь шаардлагад тохирч байгаа эсэх;
- 5.3.Цутгамал хучилтын арматурчлал, бетон цутгалтын технологи нягтаршуулалт, бат бэх нь шаардлага хангаж буй эсэх;
- 5.4.Модон хучилтын хийцлэлт, ус чийг, гал, үжлээс сэргийлэх арга хэмжээ шаардлагын дагуу авсан эсэх;
- 5.5.хавтангийн марк, чанар нь зураг төсөл, стандартад тохирч байгаа эсэх.

6.Цутгамал төмөр бетон төрөл бүрийн бүтээцэд

- 6.1.Хашмалын хэвтээ, босоо тэнхлэгийн хэмжээ, дотор гадаргуугийн тэгш, толигор байдал стандарт, дүрмийн шаардлагад нийцэж байгаа эсэх, түүний тогтворт хангагдаж байгаа эсэх;
- 6.2.Арматурын ангилал, голч байрлал, хоорондох зайд, хамгаалалтын үеийн зузаан гаргалт нь хэмжээндээ байгаа эсэх;
- 6.3.арматурын залгаас, гагнаасын байдал шаардлага хангасан эсэх;
- 6.4.Бетоны нягтуулалт, бетон хольцийн хөдөлгөөн чанар, бүтээцийн хэлбэр хэмжээ, бат бэх нь шаардлага хангасан эсэх;
- 6.5.Геометрийн хэмжээ нь зураг төсөлд нийцэж буй байдал.

7.Угсармал төмөр бетон бүтээцэд:

- 7.1.Угсралтын гагнаасын оёдлын өндөр, урт, чанар нь шаардлага хангаж буй эсэх;
- 7.2.Багана, татанга, дам нурууны хэвтээ ба босоо тэнхлэгийн шилжилт нь хүлцлийн хэмжээнд байгаа эсэх;
- 7.3. Баганын төвшин, хазайлт нь хүлцэх хэмжээнд байгаа эсэх;
- 7.4.Хавтангийн дээд, доод төвшин хүлцэх хэмжээнд байгаа эсэх;
- 7.5.Ханын хавтангийн хазайлт, шилжилт зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх;
- 7.6.Хавтгаалж болон бусад угсармал элементүүдийн булан уулзварын цулжуулалт, бетоны нягтуулалт, дулаалгын ба дуу чимээний жийргэвчийг бүрэн бүтэн хийсэн байдал;
- 7.7.Багана, дам нуруу, суурийн гүйцэтгэлийн схем;

7.8.Угсармал эдлэхүүний чанар, марк нь стандарт, зураг төслийн шаардлагад тохирч байгаа эсэх;

7.9.Угсармал эдлэхүүний дэрлэлт, зангилааны холбоос, бэхэлгээ зураг төслийн дагуу хийгдсэн эсэх.

8.Шатны ажилд:

8.1.Гишгүүрийн өндөр түүний тэгш, налуу байдал хэмжээндээ байгаа эсэх;

8.2.Шатны тавцангийн тэгш байдал шаардлагын хэмжээнд байгаа эсэх;

8.3.Шатны гуя, талбайн дам нурууны суулт, бэхлэлт, галаас хамгаалах арга хэмжээ хийгдсэн эсэх;

8.4.Гадна шат, довжооны гишгүүр, талбайн өнгөлөлт, шаардлагаас хэтэрсэн эсэх.

9. Дээврийн ажилд:

9.1.Дээврийн хэвгий, гадаргуугийн тэгш байдал шаардлагын хэмжээнд байгаа эсэх;

9.2.Дээврийн хучилтыг бэлтгэл үеийн хамт хийсэн байдал нь шаардлагад нийцсэн эсэх; (унь, дэвсгэр банзны хийцлэлт, төмрийн нугалаас, хормойвч, хар цаасны ам даралт, наалт)

9.3.Дулаалгын материалын эзэлхүүн жин, зузаан нь хэмжээнд байгаа эсэх;

9.4.Уур, ус тусгаарлалт, усны хаялага зохих ёсоор хийгдэж буй эсэх;

9.5.Хуйлмал дээврийг наахаас өмнө дулаалгыг норгосон эсэх, норохоос хамгаалсан эсэх;

9.6.Дээврийн ус тусгаарлах материалын булан, уулзварын хийцийг зураг төслийн дагуу гүйцэтгэсэн эсэх.

10.Шалны ажилд:

10.1.Модон шалны тулгуур, дэр модны байрлал, банзны.govил, банзны өргөн зэрэг нь зохих хэмжээндээ байгаа эсэх;

10.2.Шалны гадаргуугийн тэгш байдал, хэвийлт хэвийн эсэх;

10.3.Хавтанцар шалны заадас, түүний шулуун байдал хэвийн эсэх;

10.4.Нэгдүгээр давхрын шалны бэлтгэл үеийн нягтуулалт, ургамлын үндэстэй хөрсийг зайлгуулсан эсэх, бэлтгэл бетоны үеийн зузаан, тэгш байдал, бат бэх.

11.Модон бүтээцийн ажилд:

- 11.1.Өмхрөлт, ялзрал, галаас хамгаалах арга хэмжээг шаардлагын түвшинд авсан байдал;
- 11.2.Модон татангийн элементүүдийн уулзварын тэнхлэгийн огтлолцол нь шаардлага хангаж буй эсэх;
- 11.3. Булан уулзварын бэхэлгээ, холбоос, догол гаргалт нь норм дүрэмд нийцэж байгаа эсэх;
- 11.4.Геометрийн хэмжээ нь зураг төсөлд нийцэж буй эсэх;
- 11.5.Модон материал эдлэхүүний чанар, чийглэг стандартын шаардлагад тохирч байгаа эсэх;
- 11.6.Хаалга, цонхны суулгалт, бэхэлгээ, чигжээс хийлт, усны хаялга нь зураг төслийн дагуу гүйцэтгэсэн эсэх.

12.Металл бүтээцийн ажилд:

- 12.1.Уулзвар холбоосын хадаас, боолтон ба гагнаасан холбоос, түүний чанар нь шаардлагад нийцэж байгаа эсэх;
- 12.2.гагнуурын ажлын журнал хөтлөлт хэвийн эсэх;
- 12.3. Гагнаасын налуу гаргалт, оёдлын өндөр, урт нь хэмжээндээ байгаа эсэх;
- 12.4.Зэврэлтээс хамгаалах арга хэмжээ ба металл, электродын марк нь зураг төсөл, норм, дүрэмд хир нийцэж буй эсэх;
- 12.5. Геометрийн хэмжээ нь зураг төсөлд нийцэж буй эсэх;
- 12.6.Ганийн марк зураг төсөлд тусгасантай тохирсон эсэх.

13.Заслын ажилд:

- 13.1. Шавардлагын гадаргуугийн хотгор, гүдгэр, булан, уулзварын амалгааны эгц босоо байдал шаардлагад нийцэж буй байдал;
- 13.2.Будах гадаргуугийн тэгшлэлт бэлтгэл, будгийн өнгө, эмжээрийн шулуун байдал;
- 13.3. Цаасны наалт, ам даралт, шаваасны байдал шаардлагад нийцэж буй байдал;
- 13.4.Хавтанцарын хоорондох зайд, хаалт, булан уулзварын тэгш босоо болон гадаргуугийн тэгш байдал;
- 13.5. Шохойн будгийн арчигдалт, түүний тунгаалт нь стандартын шаардлага хангасан эсэх;
- 13.6.Цонхны шиллэгээний зүйдэл, зөрлөг зөв эсэх, шилний чанар (долгиотолт) бэхлэлт, битүүмжлэлт зохих ёсоор хийгдсэн эсэх;

13.7.Барилгын гадна засал чимэглэл нь зураг төсөл, хот байгуулалтад нийцэж буй эсэх.

14.Сантехникийн ажилд:

15.1. Суваг шуудуу, далангийн ул, хана, өнгөлгөө, хучлагын хийцлэлт, төвшин, геометр хэмжээ нь зохих шаардлагыг хангаж байгаа эсэх;

15.2.Яндан хоолойн байрлал, голч, зэврэлт бусад идэмхий хольцоос хамгаалах арга хэмжээнүүд нь зураг төсөл, норм дүрмийн шаардлагад нийцэж байгаа байдал;

15.3.Сантехникийн тоноглол (халаах хэрэгсэл, трап, угаагуур, тосгуур,жорлон, узель, бойлер, халаалтын болон уурын тогоо, насос)-ийн байрлал угсралт нь шаардлагад тохирсон байдал;

15.4.Яндан хоолойн тоноглолын холбох хэрэгсэл, маталт, гагнаас дулаалга, чигжээс нь зохих шаардлагыг хангаж байгаа байдал;

15.5.Яндан хоолойн хазайлт, налуу, төвшингийн байдал;

15.6.Салхивч, агааржуулалтын сувгийн огтлол, хийцлэлт нь шаардлага хангаж буй эсэх;

15.7.Гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн схем;

15.8.Дотор шугам хоолой, хэрэгслэлийн угсралтын тэгш, хазгай, босоо байдал хангагдсан эсэх, түүний хөдөлгөөнгүй бэхлэгдэлт, цэвэр үзэмжтэй харагдалт.

16.Ур, ус тусгаарлалтын ажилд:

16.1.Тусгаарлалт гадаргуугийн тэгш байдал, наалдалт;

16.2.Компенсатор залгаасын битүү байдал;

16.3. Суурь, дээвэр, хучилтын ус тусгаарлалт.

17. Барилгын цахилгааны ажилд:

17.1.Гэрлийн болон хүчит төхөөрөмжийн цахилгааны утасны угсралт, хамгаалалтын арга хэмжээ;

17.2.Цахилгааны утасны марк, огтлол, хориглосон цэгт залгасан эсэх;

17.3.Гүйцэтгэлийн схем;

17.4.газардуулгын ажлыг хэрхэн гүйцэтгэсэн байдал;

17.5.Цахилгаан дамжуулах агаарын шугамын шонгийн угсралт, тоноглолт, бэхэлгээ, утасны таталт;

17.6.Уулзвар, залгаасын холболт, хайрцаглалт, самбар, залгах, салгах хэрэгсэл (розетка, унтраалга)-ийн байрлал, угсрагдах өндөр, нам нь зохих журмын дагуу хийгдсэн эсэх.

18.Гадна тохижилтын ажилд:

18.1. Авто болон явган хүний зам талбай нь зураг төсөлд нийцэж буй эсэх;

18.2.Зүлэг, бут, сөөг, таримал ургамлын суулгалт;

18.3.Гадна зам талбайн гэрэлтүүлэг, чимэглэл шаардлага хангаж байгаа эсэх.

❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖ ❖

“Барилгын үйл ажиллагаанд оролцогч
байгууллагуудын барилгын техникийн дотоод
хяналтын жишиг дүрэм”ын дөрөвдүгээр хавсралт

**БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧ, ХАНГАН
НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ДОТООД ХЯНАЛТ**

Серийн №: 1118768547 9129308

Барилгын материал үйлдвэрлэгч, ханганд нийлүүлэгч байгууллага барилгын
техникийн дотоод хяналтаар дараах ажлыг гүйцэтгэнэ.

1. Материалын түүхий эд, бусад

- 1.1. Материалын түүхий эдэд тавигдах шаардлага хангагдсан байдлыг
хянах;
- 1.2. Түүхий эдийн дагалдах баримт бичгийн бүрдлийг хянах; /гарал үүсэл/
- 1.3. Түүхий эдийн лабораторийн хяналт, тохирлын баталгааг хянах;
- 1.4. Түүхий эдийг үйлдвэрийн дамжлагад оруулах бэлтгэлийг хангасан
байдлыг хянах;
- 1.5. Байгууллагын дотоод лабораториор түүхий эдийн чанар аюулгүй
байдалд хяналт хийх;
- 1.6. Харилцагчаас нийлүүлж байгаа түүхий эд, материалын хэмжээг хянах
хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг бэлтгэх.

2. Материал үйлдвэрлэх технологийн дамжлага

- 2.1. Үйлдвэрийн технологийн зааварчлагааг мөрдүүлж байгаад;
- 2.2. Үйлдвэрт баталгаажуулан ирүүлсэн түүхий эд, бусад бүтээгдэхүүнийг
үйлдвэрийн дамжлагад шилжүүлж байгаад хяналт тавих;
- 2.3. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний технологийн ажиллагаа эрхлэхээс
өмнө бүх тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хянах;
- 2.4. Тоног төхөөрөмж бүрд аюулгүй ажиллагааны зааварчлагаа, тэмдэглээ
байгаа эсэхийг нягтлан хянах;
- 2.5. Технологийн дамжлагад ажиллах ажилтанд аюулгүй ажиллагааны
зааварчлагаа өгсөн эсэхийг хянах.

3. Материалын бичиг баримтын бүрдүүлэл

- 3.1. Үйлдвэрлэлийн технологийн зааварчлагааг батлуулан
мөрдүүлэх;

3.2.Үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэмжил, тохирлын гэрчилгээг баталгаажуулсанд болон аюулгүй ажиллагааы зааварчилгааг батлуулан байршуулсанд;

3.3.Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ажиллуулах зааварчилгааны дүрмийг тухайн тоног төхөөрөмжийн дэргэд байрлуулах.

4.Материалын хяналт

4.1.Үйлдвэрийн технологийн дамжлагаар үйлдвэрлэгдэн бэлэн болсон бүтээгдэхүүний дээжийг дотоодын хяналтын лабораторийн хяналтанд шилжүүлсэнд;

4.2.Дотоодын хяналтын лабораторийн туршилт, шинжилгээний үр дүнтэй танилцах.

4.3. Бэлэн болсон материалын ханган нийлүүлэгчдэд нийлүүлэхэд бэлэн эсэхийг хянах. / хаяг, шошго, тэмдэглэгээ, он сар/

4.4.Бүтээгдэхүүнийг хураах, хадгалах талбай, агуулахын аюулгүй байдлыг хангуюулсан эсэх;

4.5. Бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, тээвэрлэх нөхцлийг бүрдүүлсэнд хяналт тавих.

“Барилгын уйл ажиллагаанд оролцогч
байгууллагуудын барилгын техникийн дотоод
хяналтын жишиг дүрэм”-ын тавдугаар хавсралт

**ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ УГСРАЛТ,
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫГ ТЕХНИКИЙН ДОТОOD ХЯНАЛТ**

TV31268 1118268547 9129308

Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл угсралт, засвар үйлчилгээ эрхлэх байгууллага техникийн дотоод хяналтаар дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.Өргөх механизмыг бүртгэлжүүлэх чиглэлээр:

- 1.1. “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 8.1-д заасны хэрэгжилтэд;
- 1.2.“Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.1-д заасны хэрэгжилтэд;
- 1.3. “Манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 5.1-д заасны хэрэгжилтэд;
- 1.4. “Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.1-д заасны хэрэгжилтэд;
- 1.5. “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 5.1-д заасны хэрэгжилтэд;
- 1.6.” Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 10.1-д;
- 1.7. “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 26.1-д;
- 1.8. “Зорчигчийн ган татлагат дүүжин болон чирэх замыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.1-д.

2.Өргөх механизмыг ашиглах зөвшөөрөл авсан чиглэлээр:

- 2.1. “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 8.2-д заасны хэрэгжилтэд;
- 2.2. “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.2-т заасны хэрэгжилтэд;
- 2.3. “Манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 5.2-т заасны хэрэгжилтэд;
- 2.4. “Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.2-т заасны хэрэгжилтэд;

2.5. Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааг хариуцаж байгаа бол БХБ-ын сайдын 2014 оны 07-р сарын 09-ний өдрийн 109-р тушаалаар батлагдсан “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 5.2-т заасны хэрэгжилтэд.

3.Өргөх механизмд техникийн магадлал хийсэн чиглэлээр:

3.1. “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 8.3-т заасны дагуу;

3.2. “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.3-т заасны хэрэгжилтэд;

3.3. “Манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 5.3-т заасны хэрэгжилтэд;

3.4. “Сагтай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.3-т заасны хэрэгжилтэд;

3.5. “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 5.32-5.34.9-д заасны хэрэгжилтэд.

4. Өргөх механизмын үйл ажиллагаанд хяналт, шалгалт болон үйлчилгээ хийх чиглэлээр

4.1. “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 8.4-т заасны дагуу;

4.2. “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.4-т заасны хэрэгжилтэд;

4.3. “Манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 5.4-т заасны хэрэгжилтэд;

4.4. “Сагтай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.4-т заасны хэрэгжилтэд;

4.5 “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 5.6-д заасны хэрэгжилтэд.

5. Өргөх механизмаар ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа чиглэлээр

5.1 “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 8.5-д заасны хэрэгжилтэд;

5.2 “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.5-д заасны хэрэгжилтэд;

5.3 “Манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 5.5-д заасны хэрэгжилтэд;

5.4 “Сагтай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.4-т заасны хэрэгжилтэд;

5.5 “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 3.4-д заасны хэрэгжилтэд.

Өргөх байгууламжийн машин механизм, тоног төхөөрөмжийн зураг төслийг гүйцэтгэж байгаа чиглэлээр

6.1 “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2.1-д заасны хэрэгжилтэд;

6.2 “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн -д заасны хэрэгжилтэд;

6.3 “Манипуляторт краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2.1-д заасны хэрэгжилтэд;

6.4 “Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2.1-д заасны хэрэгжилтэд;

6.5 “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 2-д заасны хэрэгжилтэд;

6.6.” Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2-д;

6.7. “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2-д;

6.8. “Зорчигчийн ган татлагат дүүжин болон чирэх замыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2.1-д;